



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 31 (604)

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *“Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин” цолоор шагнах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын дундаж норматив батлах тухай*
- *Нэн тааламжтай тариф хэрэглэх улсын жагсаалт батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот

2009 он



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Долоо хоног тутмын хэвлэл

2009 оны наймдугаар сарын 20 № 31 (604)

Улаанбаатар хот

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

433.	"Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин" цолоор шагнах тухай	Дугаар 33	711
434.	"Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин" цолоор шагнах тухай	Дугаар 34	711
435.	"Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин" цолоор шагнах тухай	Дугаар 35	712
436.	"Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин" цолоор шагнах тухай	Дугаар 36	712

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

437.	Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай	Дугаар 84	712
438.	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын дундаж норматив батлах тухай	Дугаар 85	713
439.	Талбайг нөөцөд авах тухай	Дугаар 86	713
440.	Нэн тааламжтай тариф хэрэглэх улсын жагсаалт батлах тухай	Дугаар 87	721
441.	Барааны гарал үүслийн дүрэм батлах тухай	Дугаар 88	724

Гурав. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

442.	Иргэний хуулийн 12 дугаар бүлгийн 1, 2 дугаар дэд бүлгүүдийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай	Дугаар 18	725
------	---	-----------	-----

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 33

Улаанбаатар хот

"ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН" ЦОЛООР ШАГНАХ ТУХАЙ

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын гадаад харилцааны салбарт олон жил үр бүтээл, идэвх санаачилгатай ажиллаж байгаа Гадаад харилцааны яамны Америк, Ойрхи

Дорнод, Африкийн газрын зөвлөх Түндэвдоржийн Залаа-Уулыг "Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин" цолоор шагнаусугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

"ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН" ЦОЛООР ШАГНАХ ТУХАЙ

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын гадаад харилцааны салбарт олон жил үр бүтээл, идэвх санаачилгатай ажиллаж байгаа Гадаад харилцааны яамны Төрийн дипломат

ёслолын газрын зөвлөх Намнангийн Нямжавыг "Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин" цолоор шагнаусугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

"ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН" ЦОЛООР ШАГНАХ ТУХАЙ

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын гадаад харилцааны салбарт олон жил үр бүтээлтэй, идэвх санаачилгатай

ажиллаж байгаа Гадаад харилцааны сайдын зөвлөх Гозонгийн Жаргалсайханыг "Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин" цолоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2009 оны 07 дугаар сарын 09-ний өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

"ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН" ЦОЛООР ШАГНАХ ТУХАЙ

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Монгол Улсын гадаад харилцааны салбарт олон жил үр бүтээл, идэвх санаачилгатай ажиллаж

байгаа Гадаад харилцааны яамны Азийн газрын захирал Баасанжавын Ганболдыг "Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин" цолоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ
Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 03 дугаар сарын 30-ны өдөр

Дугаар 84

Улаанбаатар хот

Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн болон яам, Засгийн газрын агентлагийн зохион байгуулалтын бүтэц өөрчлөгдсөнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хянан зохицуулах үүрэг бүхий Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг дэмжих тухай" Засгийн газрын 2006 оны

1 дүгээр сарын 4-ний өдрийн 1 дүгээр тогтоолын 2 дугаар зүйл, "Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай" Засгийн газрын 2006 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 295 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
С.БАЯР
МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
Б.ДОЛГОР

Засгийн газрын 2009 оны 84 дүгээр тогтоолын хавсралт

ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ХЯНАН ЗОХИЦУУЛАХ ҮҮРЭГ БҮХИЙ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга - Монгол Улсын Ерөнхий сайд Орлогч дарга - Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Гишүүд: - Сангийн сайд; - Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны дарга (зөвшилцсөнөөр); - Монгол Улсын Ерөнхий аудитор (зөвшилцсөнөөр);	- Үндэсний статистикийн хорооны дарга (зөвшилцсөнөөр); - Авилгатай тэмцэх газрын дарга (зөвшилцсөнөөр); - Монголын Уул уурхайн үндэсний ассоциацийн ерөнхийлөгч (тохиролцсоноор); - Монголын Үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга (тохиролцсоноор);
---	---

- "Эрдэнэт үйлдвэр" ХХК-ийн ерөнхий захирал;
 - "Айвенхоу майнз монголия инк" ХХК-ийн ерөнхий захирал;
 - "Арева Монгол" ХХК-ийн ерөнхий захирал;
 - Нээлттэй нийгэм форумын гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);
 - Хүний эрх, хөгжил төвийн тэргүүн

(тохиролцсоноор);

- "Хил хязгааргүй алхам" төрийн бус байгууллагын тэргүүн (тохиролцсоноор);
 - Нээлттэй нийгэм форумын уул уурхайн асуудал хариуцсан менежер (тохиролцсоноор);
 - Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор).
 Нарийн бичгийн дарга - Ерөнхий сайдын ахлах зөвлөх

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр

Дугаар 85

Улаанбаатар хот

Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын дундаж норматив батлах тухай

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 15.1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Цэцэрлэгийн хүүхэд бүрийн нэг өдрийн хоолны зардлыг 8-10 цагаар ажилладаг цэцэрлэгт 1100 төгрөгөөр, 24 цагаар ажилладаг цэцэрлэгт 1600 төгрөгөөр тогтоосугай.

2. Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардалд нэмж шаардагдах 8.1 (найман тэрбум нэг зуун сая) тэрбум төгрөгийг Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлэх Боловсролын үйлчилгээг дэмжих төслийн хүрээнд санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогтод зөвшөөрсүгэй.

3. Нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаж, зөрүүг нь тооцож байхыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Е.Отгонбаяр, Сангийн сайд С.Баярцогт нарт даалгасугай.

4. Хүүхдийн хоолонд хэрэглэх хүнсний бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуйн шаардлага, орчны ариун цэвэрт тогтмол хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Ц.Шийрэвдамбад үүрэг болгосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хоолны зардлын дундаж норматив батлах тухай" Засгийн газрын 2008 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн 45 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД

Е.ОТГОНБАЯР

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр

Дугаар 86

Улаанбаатар хот

Талбайг нөөцөд авах тухай

Ашигт малтмалын тухай хуулийн 9.1.7, 13.1, 13.2-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажил хийж байгаа 1 дүгээр хавсралтад заасан талбайг нөөцөд авсугай.

2. Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод даалгах нь:

а) улсын төсвийн хөрөнгөөр геологийн 1:50000-ны масштабын зураглал, ерөнхий эрлийн ажил хийж дууссан 2 дугаар хавсралтад заасан талбайн геологийн судалгааны дүнд тогтоогдсон эрдсийн хуримтлал бүхий газарт Ашигт малтмалын тухай хуулийн 19.12-т заасны дагуу сонгон

шалгаруулалтын журмаар хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох ажлыг зохион байгуулж, явцад нь бэйнгын хяналт тавьж ажилласугай;

б) тусгай хамгаалалттай газар нутагт зураглалын ажил, геологийн судалгаа явуулахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгай хамгаалалттай газар нутгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авч, хамгаалалтын захиргаатай гэрээ байгуулж ажиллуулсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ
ХҮЧНИЙ САЙД

Д.ЗОРИГТ

Засгийн газрын 2009 оны 86 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ГЕОЛОГИЙН 1:50000-НЫ МАСШТАБЫН
ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ ХИЙЖ БАЙГАА ТАЛБАЙ**

№	Талбайн нэр	Аймаг, сумын нэр, лист	Солбилцууд		Нөөцөд авах талбайн хэмжээ	Нөөцөд авсан зорилго	Нөөцөд байлгах хугацаа
1	Мөнххайрхан МХ-50	Баян-Өлгий аймгийн Булган, Ховд аймгийн Мөнххайрхан, Мөст сумд L-46-40-Б, 41-А, Б, В, Г; 42-В, (2006-2009)	47° 00' 00" 47° 00' 00" 46° 50' 00" 46° 50' 00" 46° 40' 00" 46° 40' 00" 46° 50' 00" 46° 50' 00"	91° 45' 00" 92° 30' 00" 92° 30' 00" 92° 45' 00" 92° 45' 00" 92° 00' 00" 92° 00' 00" 91° 45' 00"	2111.68	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	2 жил 9 сар
2	Хонго гол ХоГ-50	Ховд аймгийн Эрдэнэбулган сум, Баян-Өлгий аймгийн Баяннуур сумд М-46-111-В, Г; 123-А, Б, В, Г; (2006-2009)	48° 50' 00" 48° 50' 00" 48° 20' 00" 48° 20' 00"	91° 00' 00" 91° 30' 00" 91° 30' 00" 91° 00' 00"	2051.18	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	2 жил 9 сар
3	Мянгад МЯ-50	Ховд аймгийн Ховд, Мянгад, Буянт сумд М-46-135-А, Б, В, Г; 136-А, Б, В, Г; (2006-2009)	48° 20' 00" 48° 20' 00" 48° 00' 00" 48° 00' 00"	91° 00' 00" 92° 00' 00" 92° 00' 00" 91° 00' 00"	2757.12	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	2 жил 9 сар
4	Халтарын говь ХГ-50	Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Дорнод аймгийн Матад сумд L-50-53-В, Г; 54-А, Б, В, Г; 65-А, Б, В, Г; 66-А; (2006-2009)	46° 40' 00" 46° 40' 00" Монгол Улсын хил 46° 00' 00" 46° 00' 00" 46° 30' 00" 46° 30' 00"	116° 30' 00" 117° 00' 00" 117° 00' 00" Монгол Улсын хил 116° 00' 00" 116° 00' 00" 116° 30' 00"	3393	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	2 жил 9 сар
5	Баруун эрзэн БЗ-50	Дорнод аймгийн Халх гол, Сүмбэр сумд L-50-45-А, Б, В, Г; 46-А, Б, В, Г; 57-А, (2006-2009)	47° 00' 00" 47° 00' 00" Монгол Улсын хил	118° 00' 00" 119° 00' 00" 119° 00' 00" 118° 00' 00"	2328.8	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	2 жил 9 сар
6	Энгэр шанд ЭШ-50	Дундговь аймгийн Эрдэнэдалай, Адаацаг сумд L-48-54-Г; 55-В, Г; 66-Б, Г; 67-А, Б, (2006-2009)	46° 30' 00" 46° 30' 00" 46° 10' 00" 46° 10' 00" 46° 00' 00" 46° 00' 00"	104° 45' 00" 105° 30' 00" 105° 30' 00" 105° 00' 00" 105° 00' 00" 104° 45' 00"	2140.82	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	2 жил 9 сар
7	Билүүтийн даваа БИ-50	Ховд аймгийн Булган сумд L-46-62-Б, Г; 63-А, Б, В, Г; 74-Б, 75-А, Б, (2006-2009)	Монгол Улсын хил 46° 20' 00" 46° 20' 00" 45° 50' 00" Монгол Улсын хил 45° 50' 00"	Монгол Улсын хил 91° 30' 00" 91° 30' 00"	2429.01	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	2 жил 9 сар

8	Могойт хайрхан МоХ-50	Өвөрхангай аймгийн Тарагт, Хайрхандулаан, Гучин-Ус, Төгрөг, Баянгол сумд L-48-73-А,Б,В,Г; 74-А,Б,В,Г; (2006-2009)	46° 00' 00" 46° 00' 00" 44° 40' 00" 44° 40' 00"	102° 00' 00" 103° 00' 00" 103° 00' 00" 102° 00' 00"	2878.66	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	2 жил 9 сар
9	Арбулаг AP-50	Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумд L-50-74-Г, 75-В,Г; 76-А,Б,В,Г; 77-А,В; (2006-2009)	46° 00' 00" 46° 00' 00" Монгол Улсын хил 45° 40' 00" 45° 40' 00" 45° 50' 00" 45° 50' 00"	115° 30' 00" Монгол Улсын хил 114° 45' 00" 114° 45' 00" 115° 30' 00"	3090	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	2 жил 9 сар
10	Өгийнуур ӨН-50	Архангай аймгийн Хотонт, Хашаат, Өгийнуур сум, Булган аймгийн Гурванбулаг сумд L-48-15-А,Б; 14-А,Б,В,Г; (2006-2009)	47° 40' 00" 47° 40' 00" 47° 20' 00" 47° 20' 00"	102° 30' 00" 103° 15' 00" 103° 15' 00" 102° 30' 00"	2089.87	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	2 жил 9 сар
11	Бэрх уул БЗУ-50	Архангай аймгийн Хашаат сум, Булган аймгийн Гурванбулаг сумд L-48-3-А,Б, В,Г; 2-Б,Г; (2006-2009)	48° 00' 00" 48° 00' 00" 47° 40' 00" 47° 40' 00"	102° 45' 00" 103° 30' 00" 103° 30' 00" 102° 45' 00"	2085.47	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	2 жил 9 сар
12	Арвай хээрийн АрХ-50	Өвөрхангай аймгийн Тарагт, Зүүнбаян-Улаан сумд L-48-50-А,Б,В,Г; 62-А,Б, В,Г; (2006-2009)	46° 40' 00" 46° 40' 00" 46° 00' 00" 46° 00' 00"	102° 30' 00" 103° 00' 00" 103° 00' 00" 102° 30' 00"	2853.02	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	2 жил 9 сар
13	Нарийн харын талбай НХ-50	Хөвд аймгийн Үенч, Бодонч сумд L-46-74-В,Г; 75-В,Г; 86-А,Б; 87-А,Б; 88-А; (2008-2010)	45° 50' 00" 45° 50' 00" 45° 40' 00" 45° 40' 00" 45° 30' 00" 45° 30' 00"	Монгол Улсын хил 91° 30' 00" 91° 30' 00" 91° 45' 00" 91° 45' 00" Монгол Улсын хил	2579.74	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	5 жил 10 сар
14	Согоотын талбай СГ-50	Увс аймгийн Зүүнхангай, Өндөрхангай, Баруунтуруун сумд M-46-95-А,Б,В,Г; 96-А,Б,В,Г; (2008-2010)	49° 40' 00" 49° 40' 00" 49° 20' 00" 49° 20' 00"	95° 00' 00" 96° 00' 00" 96° 00' 00" 95° 00' 00"	2685.56	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	5 жил 10 сар
15	Баруун Мараатын талбай БМ-50	Завхан аймгийн Яруу, Алдархаан сумд L-47-1-А,Б, В,Г; 2-А,Б, В,Г; (2008-2010)	48° 00' 00" 48° 00' 00" 47° 40' 00" 47° 40' 00"	96° 00' 00" 97° 00' 00" 97° 00' 00" 96° 00' 00"	2774.8	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	5 жил 10 сар
16	Уст нуурын талбай УН-50	Завхан аймгийн Алдархаан, Цагаанхайрхан, Цагаанчулуут сумд L-47-13-Б, 14-А,Б,В,Г; 15-А,В; (2008-2010)	47° 40' 00" 47° 40' 00" 47° 20' 00" 47° 20' 00" 47° 30' 00" 47° 30' 00"	96° 15' 00" 97° 15' 00" 97° 15' 00" 96° 30' 00" 96° 30' 00" 96° 15' 00"	2427.4	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	5 жил 10 сар

17	Наран Сээвстэйн талбай НС-50	Говь-Алтай аймгийн Алтай, Цогт, Эрдэнэ сумд К-46-36-Б; К-47-25-А,Б,В,Г; К-47-37-А,Б,Г; К-47-38-А,Б,В,Г (2008-2011)	43° 20' 00" 43° 20' 00" 43° 00' 00" 43° 00' 00" Монгол Улсын хил	Монгол Улсын хил 96° 30' 00" 96° 30' 00" 97° 00' 00" 97° 00' 00"	2990.81	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	6 жил 3 сар
18	Хатан Суудалын талбай ХС-50	Говь-Алтай аймгийн Эрдэнэ сум, Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумд К-47-28-Б,Г; К-47-39-А,Б, В,Г; К-47-40-А,Б,В,Г; (2008-2011)	Монгол Улсын хил 43° 00' 00" 43° 00' 00" 43° 20' 00" 43° 20' 00" Монгол Улсын хил	97° 00' 00" 97° 00' 00" 97° 45' 00" 97° 45' 00" 98° 00' 00" 98° 00' 00"	3054.08	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	6 жил 3 сар
19	Хөх Бүрдийн талбай ХБ-50	Баянхонгор аймгийн Баян-Овоо, Бомьбөгөр, Галуут, Өлзийт, Эрдэнэцогт сумд L-47-69-А,Б, В,Г; L-47-70-А,Б,В,Г; (2008-2010)	46° 20' 00" 46° 20' 00" 46° 00' 00" 46° 00' 00"	100° 00' 00" 101° 00' 00" 101° 00' 00" 100° 00' 00"	2861.56	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	5 жил 10 сар
20	Жаран Богдын талбай ЖБ-50	Баянхонгор аймгийн Баянговь, Богд, Баянлиг сумд L-47-117-А,Б; L-47-118-А,Б,В,Г; (2008-2010)	45° 00' 00" 45° 00' 00" 44° 40' 00" 44° 40' 00" 44° 50' 00" 44° 50' 00"	100° 00' 00" 101° 00' 00" 101° 00' 00" 100° 30' 00" 100° 30' 00" 100° 00' 00"	2195.88	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	5 жил 10 сар
21	Бага Богдын талбай Баб-50	Баянхонгор аймгийн Богд, Баянлиг, Өвөрхангай аймгийн Баруунбаян- Улаан, Богд, Гучин-Ус сумд L-47-119-А,Б,В,Г; L-47-120-А,Б,В,Г; (2008-2011)	45° 00' 00" 45° 00' 00" 44° 40' 00" 44° 40' 00"	101° 00' 00" 102° 00' 00" 102° 00' 00" 101° 00' 00"	2929.24	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	6 жил 3 сар
22	Дэрснийн талбай ДР-50	Дундговь аймгийн Дэрэн, Дэлгэрцогт, Говь- Угтаал, Цагаандэлгэр сумд L-48-70-А,Б,В,Г; L-48-71-А,Б,В,Г; (2008-2010)	46° 20' 00" 46° 20' 00" 46° 00' 00" 46° 00' 00"	106° 30' 00" 107° 30' 00" 107° 30' 00" 106° 30' 00"	2861.56	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	5 жил 10 сар
23	Баянханы талбай БТ-50	Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Мөнххаан, Сүхбаатар, Дорнод аймгийн Хөлөнбуйр сумд L-49-22-А,Б,В,Г; 23-А,Б,В,Г; (2008-2010)	47° 40' 00" 47° 40' 00" 47° 20' 00" 47° 20' 00"	112° 30' 00" 113° 30' 00" 113° 30' 00" 112° 30' 00"	2792.32	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	5 жил 10 сар
24	Их цагаан өндөрийн талбай ИЦ-50	Дорнод аймгийн Хөлөнбуйр, Булан сумд L-49-11-А,Б,В,Г; 12-А,Б,В,Г; (2008-2010)	48° 00' 00" 48° 00' 00" 47° 40' 00" 47° 40' 00"	113° 00' 00" 114° 00' 00" 114° 00' 00" 113° 00' 00"	2774.8	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	5 жил 10 сар
25	Хасагт хайрхан-50 Хасагт Хайрхан- 5729Х	Говь-Алтай аймгийн Жаргалант, Баян-Уул, Шарга (2004-2007)	46° 40' 00" 47° 00' 00" 47° 00' 00" 46° 40' 00"	95° 00' 00" 95° 45' 00" 95° 45' 00" 95° 00' 00"	2120.2	Улсын төсвийн хөрөнгөөр геологи судалгааны ажил хийх	5 жил 10 сар

Засгийн газрын 2009 оны 86 дугаар
тогтоолын 2 дугаар хавсралт

УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР ГЕОЛОГИЙН 1:50000-НЫ МАСШТАБЫН ЗУРАГЛАЛ, ЕРӨНХИЙ ЭРЛИЙН АЖИЛ ХИЙЖ ДУУССАН ТАЛБАЙ

№	Талбайн нэр хайгуулын тусгай зөвшөөрлийн дугаар	Лист	Талбайн хэмжээ	Аймаг, сумын нэрс	Солбицлууд		Зорилго	Тайлбар
1	Ахар-Уул-1-5731Х, Ахар-Уул-2-5732Х	L-48-100- А.Б.В.Г, 112-А,Б	2187.5	Өвөрхангай, Дундговь, Өмнөговь аймгийн Төгрөг, Сайхан-Овоо, Мандал-Овоо	48°50'00"	103°30'00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэсэн талбай	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
					45°20'00"	103°30'00"		
					44°50'00"	104°00'00"		
2	Идэр гол-50 Загастай-1-8762Х, Загастай-2-8759Х, Тэлмэн-2-8760Х, Тэлмэн-1-8761Х	M-47-123- А.Б.В.Г, 124- А,В	2054.5	Завхан аймгийн Яруу, Алдархаан, Идэр, Тэлмэн	48°40'00"	97°00'00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэсэн талбай	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
					48°40'00"	97°45'00"		
					48°20'00"	97°00'00"		
3	Тал нуур-1-5726Х, Тал нуур-2-5728Х, Тал нуур-3-5734Х	M-45-144- А.В.Г, 46- 133-В.Г, 46-134-Б	2070.1	Баян-Өлгий аймгийн Дэлүүн, Алтай, Толбо	48°20'00"	89°30'00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэсэн талбай	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
					48°20'00"	90°00'00"		
					48°10'00"	90°00'00"		
4	Их хорго-5985Х, Их хорго-3-8402Х, Их хорго-3-8399Х,	L-48-17- А.Б.В.Г, 29- А,Б,Г	2449.29	Өвөрхангай, Булган, Төв аймгийн Бүрд, Рашаант, Гурванбулаг, Дашинчилэн, Эрдэнэсант	47°10'00"	104°00'00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэсэн талбай	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
					47°40'00"	104°30'00"		
					47°40'00"	104°15'00"		
5	Тармалан-8758Х	M-48-73- А.Б.В.Г, 85-А,Б	2003.9	Булган, Хөвсгөл аймгийн Тэргалан, Тэшиг, Хутаг-Өндөр	49°30'00"	102°00'00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэсэн талбай	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
					50°00'00"	102°00'00"		
					50°00'00"	102°30'00"		

6	Дөшхайрхан-5730X	L-46-35- А.Б.В.Г, 36-А.Б.В.Г	2809.8	Говь-Алтай аймгийн Жаргалант, Баян- Уул	47° 00' 00" 47° 20' 00" 47° 20' 00" 47° 00' 00"	95° 00' 00" 95° 00' 00" 96° 00' 00" 96° 00' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэсэн талбай	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
7	Богд-5733X	L-48-109- А.Б.В.Г, 121-А.Б	2200.1	Өвөрхангай аймгийн Богд, Гучин-Ус	44° 30' 00" 45° 20' 00" 45° 20' 00" 44° 30' 00"	102° 00' 00" 102° 00' 00" 102° 30' 00" 102° 30' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажилд гүйцэтгэсэн талбай	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
8	Бор-Азарга-Уул-2- 6418X Бор-Азарга-Уул-1- 6526X	L-48-1- А.Б.В.Г, 2-А.Б.	2081.1	Архангай аймгийн Батцэнгэл, Өлзийт, Гүйшүүр, Түвшнүүлэх, Цэнхэр	47° 40' 00" 48° 00' 00" 48° 00' 00" 47° 40' 00"	102° 00' 00" 102° 00' 00" 102° 45' 00" 102° 45' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэсэн талбай	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
9	АрцБогд-1-6424X АрцБогд-2-6425X	L-48-121-Б.Г, 122-А.Б.В.Г	2210.5	Өвөрхангай Өмнөговь аймгийн Богд, Булган	44° 20' 00" 44° 30' 00" 44° 30' 00" 44° 40' 00" 44° 40' 00" 44° 20' 00"	102° 00' 00" 102° 00' 00" 102° 30' 00" 102° 30' 00" 103° 00' 00" 103° 00' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэсэн талбай	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
10	Ембүү-Уул-3-6420X Ембүү-Уул-2-6421X Ембүү-Уул-1-8404X Ембүү-Уул-3-8763X	L-46-66-Б.Г, 67-А.Б.В.Г	2146.2	Ховд, Говь-Алтай аймгийн Алтай, Цэцэг, Тонхил	46° 00' 00" 46° 20' 00" 46° 20' 00" 46° 00' 00"	92° 45' 00" 92° 45' 00" 93° 30' 00" 93° 30' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэсэн талбай	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
11	Зост-Өндөр-1-8407X, Зост-Өндөр-4-8406X, Зост-Өндөр-2-8408X, Зост-Өндөр-3-8401X	L-46-48-Б.Г, 60-Б, L-47-37-В, 49-А.В	2126.8	Говь-Алтай аймгийн Шарга, Жаргалан, Тайшир	46° 30' 00" 47° 00' 00" 47° 00' 00" 46° 50' 00" 46° 50' 00" 46° 20' 00" 46° 20' 00" 46° 30' 00"	95° 45' 00" 95° 45' 00" 96° 00' 00" 96° 00' 00" 96° 15' 00" 96° 15' 00" 96° 00' 00" 96° 00' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэсэн талбай	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
12	Олон нуур-6877X	M-48-50-В, 62-Б.Г, 74-А.Б, В.Г,	2160.7	Хөвсгөл, Булган аймгийн Тарниалан, Эрдэнэбулган, Тэшиг, Хутаг-Өндөр	49° 40' 00" 50° 00' 00" 50° 00' 00" 50° 20' 00" 50° 20' 00" 50° 20' 00" Улсын хил Монгол Улсын хил 49° 40' 00"	102° 30' 00" 102° 30' 00" 102° 45' 00" 102° 45' 00" 102° 30' 00" 102° 30' 00" 103° 00' 00" 103° 00' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэсэн талбай	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан

13	Буянт-2-8405X, Буянт-1-6417X,	L-46-32- А.Б.В.Г, 44-А.Б.В.Г	2818.5	Ховд аймгийн Дарви, Говь-Алтай аймгийн Дарви, Хөхморьт	46° 40' 00" 47° 20' 00" 47° 20' 00" 46° 40' 00"	93° 30' 00" 93° 30' 00" 94° 00' 00" 94° 00' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэсэн талбай	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
14	Замтын нуруу-6246X	L-47-89- А.Б.В.Г, L-47-90- А.В.Г, L-47-101- А.Б.Г	3625.8	Говь-Алтай, Баянхонгор аймгийн Чандмань, Эрдэнэ, Баянцагаан, Баацагаан	45° 00' 00" 45° 00' 00" 45° 10' 00" 45° 10' 00" 45° 40' 00" 45° 40' 00" 45° 30' 00" 45° 30' 00" 45° 20' 00" 45° 20' 00"	98° 30' 00" 98° 15' 00" 98° 15' 00" 98° 00' 00" 98° 00' 00" 98° 45' 00" 98° 45' 00" 99° 00' 00" 99° 00' 00" 98° 30' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэсэн талбай	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
15	Дэлгэрцогт-1-6422X, Дэлгэрцогт-2-6423X,	L-48-68- А.Б.В.Г, 69-А.Б.В.Г	2861.6	Дундговь аймгийн Адаацаг, Дэлгэрцогт, Сайнцагаан	46° 20' 00" 46° 20' 00" 46° 00' 00" 46° 00' 00"	105° 30' 00" 106° 30' 00" 106° 30' 00" 105° 30' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэсэн талбай	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
16	Их Монгол уул-1- 6419X, Их Монгол уул-2- 8396X, Их Монгол уул-3- 8398X,	L-48-15-Б.Г, 16-В.Г, 28-А.Б	2098.62	Архангай, Булган аймгийн Хашаат, Гурванбулаг	47° 40' 00" 47° 40' 00" 47° 30' 00" 47° 30' 00" 46° 10' 00" 46° 10' 00" 47° 20' 00" 47° 20' 00"	103° 15' 00" 103° 30' 00" 103° 30' 00" 104° 00' 00" 103° 30' 00" 103° 30' 00" 103° 00' 00" 103° 15' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэсэн талбай	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
17	Улаан даваа -50 Өргөдөл 13255X, Өргөдөл 13257X, Өргөдөл 13256X, Өргөдөл 13258X,	M-46-51- Б.Г 52-А.В, 63-Б, 64-А.В	2064	Увс аймгийн Сагил, Түргэн	Монгол Улсын хил 50° 40' 00" 91° 15' 00" 50° 40' 00" 50° 00' 00" 50° 00' 00" 50° 10' 00" 50° 10' 00"	Монгол Улсын хил 91° 15' 00" 91° 45' 00" 91° 45' 00" 91° 30' 00" 91° 30' 00" 91° 15' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэсэн талбай	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
18	Мордон -50 Өргөдөл 13282X,	L-50-43-В.Г, 44-В.Г, 55-А.Б.В.Г, 56-А.Б	2871.1	Дорнод аймгийн Матад, Халх гол	Монгол Улсын хил 46° 21' 50" 46° 50' 00" 46° 50' 00" 46° 37' 00"	Монгол Улсын хил 117° 00' 00" 117° 00' 00" 118° 00' 00" 118° 00' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил гүйцэтгэсэн талбай	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан

19	Баян-Уул-50 Өргөдөл 13347X, Өргөдөл 13347-3X, Өргөдөл 13347-2X, Өргөдөл-13347-1X.	L-46-22-Б.Г, 33-Б, 34-А,Б,Б.Г, 46-Б.Г.	3161.55	Говь-Алтай аймгийн Хохоморг, Баян-Уул, Шарга, Хохоморат	47° 00' 00" 47° 10' 00" 47° 10' 00" 47° 20' 00" 47° 30' 00" 47° 30' 00" 46° 40' 00" 46° 40' 00" 47° 00' 00" 47° 00' 00"	94° 30' 00" 94° 30' 00" 94° 15' 00" 94° 30' 00" 95° 00' 00" 95° 00' 00" 94° 45' 00" 94° 45' 00" 94° 30' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
20	Дорнод -50 Өргөдөл 13348X, Өргөдөл 13349X, Өргөдөл 13350X, Өргөдөл-13351X.	M-46-126- А,Б,В.Г, 127- В.Г, 138-Б.Г, 139-А,Б	3441.98	Завхан, Ховд, Увс аймгийн Дорнод, Урсгал, Завхан, Өлгий, Чандмань	48° 20' 00" 48° 20' 00" 48° 20' 00" 48° 40' 00" 48° 40' 00" 48° 30' 00" 48° 30' 00" 48° 10' 00" 48° 10' 00" 48° 00' 00" 48° 00' 00"	92° 45' 00" 92° 45' 00" 92° 30' 00" 93° 00' 00" 93° 00' 00" 93° 30' 00" 93° 30' 00" 93° 00' 00" 93° 00' 00" 93° 00' 00" 92° 45' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
21	Алтайбулаг-50 Алтайбулаг-1-6737X, Алтайбулаг-2-6736X, Алтайбулаг-68, Алтайбулаг-7-6738X, Алтайбулаг-4-6739X, Алтайбулаг-6-6740X, Алтайбулаг-5-6741X, Алтайбулаг-3-8764X.	M-49-56-В.Г, 57-В.Г, 68- А,Б,Г, 69-А,Б, В,Г, 70-А,Б,В, Г, 71-А,Б.	3700	Сэлэнгэ аймгийн Шаламар, Түшиг, Цагааннуур, Зүүнбурэн, Алтайбулаг	Монгол Улсын хил 50° 00' 00" 50° 00' 00" 50° 10' 00" 50° 10' 00"	111° 00' 00" 111° 00' 00" 111° 30' 00" 111° 30' 00" 111° 00' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
22	Баянхайн хонгор-50 Баянхай хонгор Уул-8400X	L-49-106-Б.Г, 107-В.Г, 118-А,Б, 119-А,Б,В.Г.	2990.04	Сүхбаатар аймгийн Онгон	Монгол Улсын хил 45° 10' 00" 45° 10' 00"	112° 30' 00" 112° 30' 00" 113° 30' 00" 113° 30' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
23	Нямрочирын гол-50 Өргөдөл 13281X, Өргөдөл 13284X	L-50-35-Б.Г, 36-А,В.Г, 47-А,Б,В.Г, 59-А,Б	2994.08	Дорнод аймгийн Халх гол, Сүмбэр	Монгол Улсын хил 46° 44' 50" 47° 00' 00" 47° 00' 00" 47° 20' 00"	119° 00' 00" 119° 00' 00" 119° 15' 00" 119° 15' 00" 119° 30' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
24	Янгирт Улаан-50 Баян-Овоо 1647X, Эрдэнэчулуут-1643X, Малын-644X, Толгой-644X, Эрдэнэчулуут-7188X	L-46-47- А,Б,В.Г, 48-А,В	3202.0	Говь-Алтай аймгийн Алтай сум	Монгол Улсын хил 45° 20' 50" 45° 20' 00" 45° 20' 00" Монгол улсын хил	94° 00' 00" 94° 00' 00" 94° 30' 00" 94° 30' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан
25	Гураван-Овоот-50 Гураван-Овоот-8397X	L-49-103-Б.Г, 104-В.Г, 115-А,Б, 116-А,Б,В	2613	Дорноговь аймгийн Өргөн, Эрдэнэ	Монгол Улсын хил 44° 40' 00" 44° 40' 00" 44° 50' 00" 44° 50' 00"	112° 00' 00" 111° 30' 00" 111° 30' 00" 111° 00' 00"	Улсын төсвийн хөрөнгөөр геологийн судалгааны ажил хийгдэж дууссан



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр

Дугаар 87

Улаанбаатар хот

Нэн тааламжтай тариф хэрэглэх улсын жагсаалт батлах тухай

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4.5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Нэн тааламжтай тариф хэрэглэх Дэлхийн худалдааны байгууллагын гишүүн орнуудын жагсаалт"-ыг 1 дүгээр хавсралт, "Олон улсын бусад гэрээний дагуу хөнгөлөлттэй тариф хэрэглэхээр

тохиролцсон орнуудын жагсаалт"-ыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД****С.БАЯР****САНГИЙН САЙД****С.БАЯРЦОГТ**

Засгийн газрын 2009 оны 87 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

НЭН ТААЛАМЖТАЙ ТАРИФ ХЭРЭГЛЭХ ДЭЛХИЙН ХУДАЛДААНЫ БАЙГУУЛЛАГЫН ГИШҮҮН ОРНУУДЫН ЖАГСААЛТ

№	Улсын нэр	
	Монгол хэлээр	Англи хэлээр
1	Австрали Улс	Australia
2	Америкийн Нэгдсэн Улс	United States of America
3	Арабын Бүгд Найрамдах Египет Улс	Arab Republic of Egypt
4	Антигуа ба Барбуда	Antigua and Barbuda
5	Балбын Вант Улс	Kingdom of Nepal
6	Барбадос	Barbados
7	Бахрейн Улс	State of Bahrain
8	Белиз	Belize
9	Бельгийн Вант Улс	Kingdom of Belgium
10	Ботсван	Botswana
11	Бүгд Найрамдах Австри Улс	Republic of Austria
12	Бүгд Найрамдах Албани Улс	Republic of Albania
13	Бүгд Найрамдах Ангол Ард Улс	Republic of Angola
14	Бүгд Найрамдах Аргентин Улс	The Argentine Republic
15	Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улс	Democratic Republic of the Congo
16	Бүгд Найрамдах Ардчилсан Социалист Шри Ланк Улс	Democratic Socialist Republic of Sri Lanka
17	Бүгд Найрамдах Армян Улс	Republic of Armenia
18	Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс	People's Republic of Bangladesh
19	Бүгд Найрамдах Бенин Улс	Republic of Benin
20	Бүгд Найрамдах Болгар Улс	Republic of Bulgaria
21	Бүгд Найрамдах Боливи Улс	Republic of Bolivia
22	Бүгд Найрамдах Венесуэль Улс	Republic Bolivariana of Venezuela
23	Бүгд Найрамдах Гайана Улс	Cooperative Republic of Guyana
24	Бүгд Найрамдах Гана Улс	Republic of Ghana
25	Бүгд Найрамдах Гватемал Улс	Republic of Guatemala
26	Бүгд Найрамдах Гвиней Улс	Republic of Guinea
27	Бүгд Найрамдах Гвиней-Бисау Улс	Republic of Guinea-Bissau
28	Бүгд Найрамдах Грек Улс	Republic of Greece
29	Бүгд Найрамдах Доминикан Улс	Dominican Republic
30	Бүгд Найрамдах Замби Улс	Republic of Zambia
31	Бүгд Найрамдах Зимбабве Улс	Republic of Zimbabwe



32	Бүгд Найрамдах Индонези Улс	Republic of Indonesia
33	Бүгд Найрамдах Ирланд Улс	Ireland
34	Бүгд Найрамдах Исланд Улс	Republic of Iceland
35	Бүгд Найрамдах Итали Улс	Republic of Italy
36	Бүгд Найрамдах Кабо-Верде Улс	Republic of Cape-Verde
37	Бүгд Найрамдах Кипр Улс	Republic of Cyprus
38	Бүгд Найрамдах Кыргызстан Улс	Kyrgyz Republic
39	Бүгд Найрамдах Колумби Улс	Republic of Colombia
40	Бүгд Найрамдах Конго Улс	Republic of the Congo
41	Бүгд Найрамдах Коста-Рика Улс	Republic of Costa Rica
42	Бүгд Найрамдах Куба Улс	Republic of Cuba
43	Бүгд Найрамдах Латви Улс	Republic of Latvia
44	Бүгд Найрамдах Литва Улс	Republic of Lithuania
45	Бүгд Найрамдах Мадагаскар Улс	Republic of Madagascar
46	Бүгд Найрамдах Македон Улс	Republic of Macedonia
47	Бүгд Найрамдах Мальдив Улс	Republic of Maldives
48	Бүгд Найрамдах Мали Улс	Republic of Mali
49	Бүгд Найрамдах Мальт Улс	Republic of Malta
50	Бүгд Найрамдах Мозамбик Улс	Republic of Mozambique
51	Бүгд Найрамдах Молдов Улс	Republic of Moldova
52	Бүгд Найрамдах Намиби Улс	Republic of Namibia
53	Бүгд Найрамдах Никарагуа Улс	Republic of Nicaragua
54	Бүгд Найрамдах Нэгдсэн Танзани Улс	United Republic of Tanzania
55	Бүгд Найрамдах Парагвай Улс	Paraguay
56	Бүгд Найрамдах Перу Улс	Republic of Peru
57	Бүгд Найрамдах Польш Улс	Republic of Poland
58	Бүгд Найрамдах Португал Улс	Republic of Portugal
59	Бүгд Найрамдах Сальвадор Улс	Republic of El Salvador
60	Бүгд Найрамдах Сенегал Улс	Republic of Senegal
61	Бүгд Найрамдах Сингапур Улс	Republic of Singapore
62	Бүгд Найрамдах Словак Улс	Slovak Republic
63	Бүгд Найрамдах Словени Улс	Republic of Slovenia
64	Бүгд Найрамдах Солонгос Улс	Republic of Korea
65	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс	Socialist Republic of Viet Nam
66	Бүгд Найрамдах Тунис Улс	Republic of Tunisia
67	Бүгд Найрамдах Турк Улс	Republic of Turkey
68	Бүгд Найрамдах Унгар Улс	Republic of Hungary
69	Бүгд Найрамдах Филиппин Улс	Republic of the Philippines
70	Бүгд Найрамдах Финланд Улс	Republic of Finland
71	Бүгд Найрамдах Франц Улс	Republic of France
72	Бүгд Найрамдах Хорват Улс	Republic of Croatia
73	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	People's Republic of China
74	Бүгд Найрамдах Чех Улс	Czech Republic
75	Бүгд Найрамдах Чили Улс	Republic of Chile
76	Бүгд Найрамдах Эквадор Улс	Republic of Ecuador
77	Бүгд Найрамдах Энэтхэг Улс	Republic of India
78	Бүгд Найрамдах Эстони Улс	Republic of Estonia
79	Буркино Фасо	Burkina Faso
80	Бурунд	Burundi
81	Брунейн Вант Улс	Brunei Darussalam
82	Габон	Gabon
83	Гаити	Haiti
84	Гамби	The Gambia
85	Гондурас	Honduras

86	Гренада Улс	Grenada
87	Гүрж Улс	Georgia
88	Данийн Вант Улс	Kingdom of Denmark
89	Джибути	Djibouti
90	Доминикан	Dominica
91	Дорнын Бүгд Найрамдах Уругвай Улс	Oriental Republic of Uruguay
92	Европын Холбоо	European Union
93	Зааны ясан эргийн БНУ	Cote d'Ivoire
94	Израиль Улс	State of Israel
95	Испани Улс	Spain
96	Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Вант Улс	United Kingdom of Great Britain and Northern Ireland
97	Йорданы Хашимитын Вант Улс	Hashimite Kingdom of Jordan
98	Камерун	Cameroon
99	Камбожийн Вант Улс	Kingdom of Cambodia
100	Канад Улс	Canada
101	Катар Улс	State of Qatar
102	Кени	Kenya
103	Кувейт Улс	State of Kuwait
104	Лалын Бүгд Найрамдах Мавритани Улс	Republic of Mauritania
105	Лалын Бүгд Найрамдах Пакистан Улс	Islamic Republic of Pakistan
106	Лесотогийн Вант Улс	Kingdom of Lesotho
107	Лихтенштейний Вант Улс	Liechtenstein
108	Люксембургийн Их Вант Улс	Grand Duchy of Luxembourg
109	Маврикий	Mauritius
110	Макао	Macao, China
111	Малави	Malawi
112	Малайз Улс	Malaysia
113	Марокхын Вант Улс	Kingdom of Morocco
114	Мексикийн Нэгдсэн Улс	United Mexican States
115	Мьянмарийн Холбооны Улс	Union of Myanmar
116	Нигер	Niger
117	Нидерландын Вант Улс	Kingdom of the Netherlands
118	Норвегийн Вант Улс	Kingdom of Norway
119	Нэгдсэн Арабын Эмират Улс	United Arab Emirates
120	Оманы Султант Улс	Sultanate of Oman
121	Өмнөд Африкийн Бүгд Найрамдах Улс	Republic of South Africa
122	Панам	Panama
123	Папуа Шинэ Гвиней Улс	Papua New Guinea
124	Руанда	Rwanda
125	Румын Улс	Romania
126	Саудын Арабын Вант Улс	Kingdom of Saudi Arabia
127	Свазиленд	Swaziland
128	Сент-Китс ба Нэвис	Saint Kitts and Nevis
129	Сент-Винсент ба Гренадин	Saint Vincent & the Grenadines
130	Сент-Люси	Saint Lucia
131	Соломоны арлууд	Solomon Islands
132	Суринам	Suriname



133	Сьерра-Леоне	Sierra Leone
134	Сянган/Гонконг/	Hong Kong, China
135	Тайвань	Chinese Taipei
136	Тайландын Вант Улс	Kingdom of Thailand
137	Togo	Togo
138	Тонгагийн Вант Улс	Kingdom of Tonga
139	Төв Африкийн БНУ	Central African Republic
140	Тринидад ба Тобаго	Trinidad and Tobago
141	Уганда	Uganda
142	Украйн Улс	Ukraine
143	Фижийн Арлуудын Бүгд Найрамдах Улс	Republic of the Fiji Islands
144	Холбооны Бүгд Найрамдах Бразил Улс	Federative Republic of Brazil
145	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	Federal Republic of Germany
146	Холбооны Бүгд Найрамдах Нигери Улс	Federal Republic of Nigeria
147	Чад	Chad
148	Шведийн Вант Улс	Kingdom of Sweden
149	Швейцарийн Холбооны Улс	Swiss Confederation
150	Шинэ Зеланд Улс	New Zealand
151	Ямайка	Jamaica
152	Япон Улс	Japan

Засгийн газрын 2009 оны 87 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ОЛОН УЛСЫН БУСАД ГЭРЭЭНИЙ ДАГУУ ХӨНГӨЛӨЛТТЭЙ ТАРИФ ХЭРЭГЛЭХЭЭР ТОХИРОЛЦСОН ОРНУУДЫН ЖАГСААЛТ

№	Улсын нэр	
	Монгол хэлээр	Англи хэлээр
1	Бүгд Найрамдах Беларусь Улс	Republic of Belarus
2	Бүгд Найрамдах Казахстан Улс	Republic of Kazakhstan
3	Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улс	Lao People's Democratic Republic
4	Оросын Холбооны Улс	Russian Federation

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2009 оны 04 дүгээр сарын 01-ний өдөр

Дугаар 88

Улаанбаатар хот

Барааны гарал үүслийн дүрэм батлах тухай

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 26.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Барааны гарал үүслийн дүрэм"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү тогтоолын хавсралтаар баталсан "Барааны гарал үүслийн дүрэм"-ийг буцаан хэрэглэхгүй байхаар тогтоосугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Сангийн сайд С.Баярцогтод үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

С.БАЯР

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

Засгийн газрын 2009 оны 88 дугаар тогтоолын хавсралт

БАРААНЫ ГАРАЛ ҮҮСЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын гаалийн нутаг дэвсгэрт оруулах бараанд нэн тааламжтай тариф хэрэглэх, эдийн засаг, худалдааны бодлого хэрэгжүүлэх

зорилгоор импортын барааны гарал үүслийн улсыг тогтооход барааны гарал үүслийн дүрэм /цаашид "дүрэм" гэх/-ийг хэрэглэнэ.



1.2. Барааны гарал үүслийн улс гэдэгт барааг бүрэн үйлдвэрлэсэн, эсхүл үлэмж хэмжээний боловсруулалт хийсэн улсыг ойлгоно.

1.3. Барааны гарал үүслийн улсыг Дэлхийн худалдааны байгууллагын Гарал үүслийн дүрмийн тухай хэлэлцээр, Дэлхийн гаалийн байгууллагын Гаалийн бүрдүүлэлтийн горимыг хялбарчлах, уялдуулах тухай конвенцийг үндэслэн Гаалийн тариф, гаалийн татварын тухай хууль болон энэ дүрмийн дагуу тодорхойлно.

1.4. Гаалийн ерөнхий газар барааны гарал үүслийн улсыг тодорхойлоход мөрдөх хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэрийг нийтэд мэдээлж сурталчлах ажлыг хариуцна.

Хоёр. Барааны гарал үүслийн улсыг тодорхойлох

2.1. Импортын барааны гарал үүслийг Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 27, 28 дугаар зүйлийн дагуу тодорхойлно.

2.2. Монгол Улсын түүхий эдээр хилийн чанадад үйлдвэрлэсэн бараа нь Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 29.2.1-29.2.3 дахь заалтад дурдсан шалгуурт хамаарна.

2.3. Үлэмж хэмжээний боловсруулалт хийгдсэнийг тогтоох шалгуурыг дараахь бараанд хэрэглэхгүй:

2.3.1. ашигт малтмал;

2.3.2. амьтан, амьтны гаралтай бүтээгдэхүүн;

2.3.3. загас, загас агнуурын бүтээгдэхүүн;

2.3.4. тухайн оронд бүтээгдсэн хоёрдогч түүхий эд;

2.3.5. энэ дүрмийн 2.3.1-2.3.4-т заасан бүтээгдэхүүнээр тухайн улсад үйлдвэрлэсэн бараа.

Гурав. Барааны гарал үүслийн улсыг нотлох баримт

3.1. Барааны гарал үүслийн улсыг нотлоход Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 31.1, 31.2 дахь хэсэгт заасныг баримтална.

3.2. Худалдах, хэрэглэх, эсхүл ашиглах зориулалттай, нийт үнийн дүн нь 1000 ам. доллараас хэтрэхгүй бараанд барааны гарал үүслийн мэдүүлэг, эсхүл барааны гарал үүслийг баталгаажуулсан мэдүүлгийг үндэслэн нэн тааламжтай тариф хэрэглэнэ.

3.3. Гарал үүслийн гэрчилгээг дараахь тохиолдолд шаардана:

3.3.1. Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжоор барааны гарал үүслийн гэрчилгээ шаардсан;

3.3.2. Монгол Улсын хууль тогтоомжоор гаалийн тарифын бус зохицуулалт /тодорхой барааг тодорхой улсаас Монгол Улсын хилээр оруулахыг хориглох, квот тогтоох гэх мэт/ хийсэн;

3.3.3. барааны гарал үүслийн улс нь түүнийг нотлох бусад бичиг баримтад тодорхой тусгагдаагүй.

3.4. Барааны гарал үүслийн гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Дөрөв. Барааны гарал үүслийн улсыг мэдүүлэх

4.1. Барааны гарал үүслийн улсыг мэдүүлэгч холбогдох нотлох баримтыг үндэслэн гаалийн мэдүүлгийг нөхөн бичих замаар гаалийн байгууллагад мэдүүлнэ.

4.2. Мэдүүлэгч нь барааны гарал үүслийн улсыг энэ дүрмийн дагуу өөрөө тодорхойлно.

Тав. Барааны гарал үүслийн улсыг гаалийн байгууллага шалгах, шийдвэр гаргах

5.1. Гаалийн байгууллага барааны гарал үүслийн улсыг мэдүүлэгч үнэн зөв мэдүүлсэн эсэхийг дараахь нөхцөлд шалгана:

5.1.1. гаалийн бүрдүүлэлтийн явцад;

5.1.2. гаалийн хяналтын явцад;

5.1.3. Барааг мэдүүлэгчийн сонгосон горимд байршуулсны дараа.

5.2. Гаалийн байгууллага барааны гарал үүслийн улсын талаархи шийдвэрийг дараахь тохиолдолд гаргана:

5.2.1. мэдүүлэгч энэ дүрмийн дагуу гарал үүслийн улсыг тодорхойлж мэдүүлээгүй бол;

5.2.2. Дэлхийн гаалийн байгууллага, бусад улсын гаалийн байгууллага болон олон улсын байгууллагын хүсэлтээр;

5.2.3. хууль, хяналтын байгууллагын хүсэлтээр.

5.3. Гаалийн байгууллага барааны гарал үүслийн улсыг нягтлан шалгаж, тогтоох зорилгоор барааны загварыг авч, шинжиж болно.

Зургаа. Бусад

6.1. Барааны гарал үүслийн улсыг тодорхойлохтой холбогдон гарсан зөрчил, маргааныг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

2009 оны 06 дугаар сарын 15-ны өдөр

Дугаар 18

Улаанбаатар хот

Иргэний хуулийн 12 дугаар бүлгийн 1, 2 дугаар дэд бүлгүүдийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай

Өмчийн харилцааны нийтлэг үндэслэл болон өмчлөх эрх үүсэх, дуусгавар болохыг зохицуулсан Иргэний хуулийн 12 дугаар бүлгийн 1, 2 дугаар дэд бүлгүүдийн зарим зүйл, заалтыг нэг мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол Улсын Үндсэн хуулийн

тавьдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, Шүүхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.5-д заасныг удирдлага болгон Улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Өмчлөх эрхийг тодорхойлсон хуулийн 101 дүгээр зүйлийн зарим заалтыг дараах байдлаар тайлбарласугай.

1.1. Энэ зүйлийн 101.1.-д зааснаар өмчлөгч нь өмчлөлийн зүйлээ **"аливаа халдлагаас хамгаалах эрх"**-ээ эрх бүхий байгууллагад хандах замаар, эсхүл өөрийн шаардлага болон үйлдлээр тус тус хэрэгжүүлнэ.

1.2. Мөн зүйлийн 101.2.-т заасан **"өмчлөх эрхээ урвуулан ашиглах"** гэдэгт өмчлөгч өөрийн бүрэн эрхийг бусдын ашиг сонирхолд санаатайгаар харш хэрэгжүүлэхийг ойлгоно. Энэ тохиолдолд өмчлөгч бусад этгээдэд гэм хор заавал учруулсан байдгийг анхаарвал зохино.

1.3. Энэ зүйлийн 101.5.-д заасан **"бүрдэл хэсэг"** гэдгийг хуулийн 85 дугаар зүйлд заасны дагуу ойлгож хэрэглэнэ.

2. Эзэмшилд байх хугацаанаас шалтгаалж өмчлөх эрх олж авахыг зохицуулсан хуулийн 104 дүгээр зүйлийн зарим заалтыг доорх байдлаар тайлбарласуяй.

2.1. Энэ зүйлийн 104.1.-д заасан **"эзэнгүй эд юмс"** гэдэгт хуулийн 115 дугаар зүйлийн 115.1.-д заасан эд юмс хамаарна.

Мөн заалтын **"илээр, шударгаар олж авсан"** гэдгийг хууль ёсны болон олон нийтэд нээлттэй аргаар эзэмшилдээ илжүүлснийг ойлгоно.

2.2. Мөн зүйлийн 104.2.-т заасан **"өмчлөх эрхийг олж авна"** гэснийг эзэмшигч нь эд хөрөнгийн эзэмшилдээ хуульд заасан 15 жилийн хугацааны турш эзэмшиж, ашигласны дараа Эд хөрөнгө өмчлөх эрх, түүнтэй холбоотой эд хөрөнгийн бусад эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.-д заасны дагуу эрхийн улсын бүртгэлд бүртгүүлж, гэрчилгээ авснаар түүний өмчлөх эрх баталгаажна гэж ойлговол зохино.

Харин энэ зүйл, хэсэгт заасан **"улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш"** гэдгийг хуулийн 185 дугаар зүйлд зааснаар улсын бүртгэлд урьдчилсан тэмдэглэл хийлгэсний дараа гэж ойлгоно.

3. Хуулийн 106 дугаар зүйлийн 106.1.-д заасан **"өмчлөгч хөрөнгөө бусдын хууль бус эзэмшлээс шаардах"** нь зөвхөн хууль бус эзэмшилд хамаарна. Харин хуулийн 93 дугаар зүйлийн 93.1.-д зааснаар хууль ёсны эзэмшлээс өмчлөгч ч эд хөрөнгө шаардах эрхгүй.

Өмчлөх эрх шилжүүлэх гэрээний үүргийн биелэлтийн шаардлага тухайн гэрээний зохицуулалтад хамаарах тул энэ заалтыг гэрээний харилцаанаас үүссэн маргааныг хянан шийдвэрлэхэд давхар баримтлах шаардлагагүй.

4. Хуулийн 119 дүгээр зүйлийн 119.3., 120 дугаар зүйлийн 120.2.-т заасан **"учирсан хохирол"** гэдэгт эрх нь зөрчигдсөн этгээдийн эд хөрөнгө нийлэх, холилдох, дахин боловсруулахаас өмнө оруулсан хөрөнгөөс гадна хуулийн 227 дугаар зүйлийн 227.3.-т заасан бусад хохирол хамаарч болно.

5. Хуулийн 121 дүгээр зүйлийн 121.1.-д **"бусад этгээдийн эд хөрөнгийн хувьд эдлэх**

аливаа эрх дуусгавар болно" гэж заасны дагуу холилдсон, нийлсэн, дахин боловсруулагдсан эд хөрөнгийн талаар тэдгээрийн өмчлөгчдөөс өөр бусад этгээд ямар нэг эрхтэй байсан (барьцааны эрх г.м.) боловч тухайн эд хөрөнгө өөр хөрөнгөтэй холилдож, нийлж, дахин боловсруулагдсанаар шинэ эд хөрөнгө бий болсон учир хуучин эд хөрөнгийн талаарх эрх хэрэгжих боломжгүй тул энэ тохиолдолд эрх эзэмшигч шаардлагаа хуульд заасан өөр хэлбэрээр хангуулна.

6. Хуулийн 122 дугаар зүйлийн 122.1.-д заасан **"хуульд өөрөөр заагаагүй бол оюуны өмчид хамаарах оюуны үнэт зүйлийг бүтээсэн этгээдийн өмчлөх эрх уг зүйлийг бүтээсэн үзэс үүснэ"** гэдгийг Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.-д зааснаар утга зохиол, урлагийн бүтээлийн өмчлөх эрх бүтээлийг бүтээсэн үзэс, Патентын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1., Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.-д зааснаар патент олгосон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, гэрчилгээ олгосон ашигтай загвар, барааны тэмдэг, гэрчлэх тэмдэг, хамтын тэмдгийн өмчлөх эрх зэрэгт мэдүүлгийн анхдагч огнооноос эхлэн тус тус үүснэ гэж ойлгоно.

7. Хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.-т зааснаар **"шаардах эрх шилжүүлэх"**-эд шаардах эрх эзэмшигч нь шаардах эрхээ бусдад шилжүүлэхдээ үүрэг гүйцэтгэгчид энэ талаар мэдэгдэх 1 үүрэгтэй болохоос түүний зөвшөөрлийг авах, шаардах эрхээ шилжүүлж буй гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний талаар танилцуулах зэрэг ажиллагаа явуулах шаардлагагүй. Харин мөн зүйлийн 123.3.-т заасны дагуу үүрэг гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд шаардах эрх шилжүүлэхийг хязгаарлах талаар харилцан тохиролцсон бол шаардах эрхийг шилжүүлэх ажиллагаа тухайн гэрээний дагуу зохицуулагдана.

8. Хуулийн 124 дүгээр зүйлийн 124.1.-д **"Эзэмшигчтэй нь тохиролцсоноор үүрэг гүйцэтгэгчийн өрийг гуравдагч этгээд шаардах эрхийг өөртөө шилжүүлэн авч үүрэг гүйцэтгэж болно"** гэснийг дараах байдлаар тайлбарласуяй.

8.1. **"Тохиролцсоноор"** гэж бусдын өрийг шилжүүлж авч буй этгээд үүрэг гүйцэтгүүлэгчээс заавал зөвшөөрөл авсан байхыг хэлнэ. Уг тохиролцоо нь үүргийн талаарх хэлцэлтэй хэлбэрийн хувьд адил байна.

8.2. Үүргийн биелэлтийг хангах арга болох барьцаа, батлан даалт, баталгаа, банкны баталгаа зэрэг нь үүрэг гүйцэтгэгчийн хувийн байдалтай шууд холбоотой тул зөвхөн түүний үүргийн биелэлтийг хангах талаар өгсөн бусдын амлалт өөр үүрэг гүйцэтгэгчид хамааралгүй болно.

**ЕРӨНХИЙ
ШҮҮГЧ**

С.БАТДЭЛГЭР

ШҮҮГЧ

Л.БЯМБАА

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас эрхлэн гаргав.

Улсын Их Хурлын Тамгын газрын

Хаяг: <<Төрийн мэдээлэл>> эмхтгэлийн редакци.

Хэвлэх хэсэгт хэвлэв.